210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,861,023.00	46,991,314.00
210502	Хоол, хүнс		6,096,820.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	440,000.00	7,701,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	440,000.00	7,045,000.00
210604	Урсгал засвар		656,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,497,690.00	56,290,048.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,497,690.00	56,290,048.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,966,050.00	104,842,926.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110,966,050.00	104,742,926.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,039,300.00	54,470,962.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,039,300.00	24,497,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,439,300.00	13,832,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,900,000.00	9,156,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,700,000.00	1,508,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,407,207.80	29,973,862.07
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	20,659,607.80	29,973,862.07
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	747,600.00	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	224,569,070.80	320,979,551.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	224,569,070.80	320,979,551.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	54,434,273.00	94,582,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,725,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	134,035,897.80	160,265,974.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,673,900.00	66,131,277.70
131106	Төсвийн урамшуулал	12,700,000.00	-
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		1,966,935.68
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,966,935.68

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн данс, орлогыг жигд ханган биелүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 08-ны өдрийн 01/31 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн эрхэм зорилго нь “Хүний хөгжлийн үндсэн үзүүлэлтүүдийг хангасан мал аж ахуй газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ тогтвортой хөгжих нөхцөл боломж бүрдсэн, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан сум болж хөгжинө” гэж тодорхойлсон байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлан нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан журмыг баримтлан сумын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулсан байна. Засаг даргын захирамжаар дотоод хяналт шалгалтын 5 гишүүнээс бүрдсэн ажлын хэсгийг байгуулан ажлыг төлөвлөгөөг жил бүр батлуулан хэрэгжүүлж, үр дүнг тооцоон хэрэгжилтийн явцыг улирал бүр Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт дотоод аудитын албанаас Алтанбулаг сумын төсөвт байгууллагуудын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 49,925.9 мянган төгрөгийн албан шаардлага, 28,149.3 мянган төгрөгийн акт тогтоосныг 100% барагдуулж, төсөвт байгууллагуудын эрсдэлийн үнэлгээг дунд гэж үнэлсэн байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын

гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зарлагын 11,644,479.9 мянган төгрөгөөс 1,0 хувиар буюу 116,444.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 81,511.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас дахин тооцож үзэхэд гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 52,305.8 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 64,138.9 мянган төгрөгөөр буурсан тул төлөвлөлтийн үе шатны материаллаг түвшинг 116,444.8 мянган төгрөгөөр хэвээр үлдээж дахин тооцох шаардлагагүй гэж үзэв.

Учир нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон нийт зарлага 11,644,479.9 мянган төгрөг, гүйцэтгэлийн үе шатны зарлага 5,230,584.4 мянган төгрөг, 6,413,895.5 мянган төгрөгөөр зарлага буурсан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, төрийн сан, сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, эм эргэлтийн сан, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 11 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем программыг ашиглаж байна.

Орлогын талаар:

Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 663,986.3 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжилт 1,411,725.2 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 20,695.8 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн сангийн санхүүжилт 96,351.4 мянган төгрөг, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 172,999.6 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн орлого 61,181.6 мянган төгрөг, бусад орлого 18,063.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 320,979.5 мянган төгрөг, орон нутгийн төсвийн орлого 438,636.2 мянган төгрөг, нийт 3,204,618.9 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг мөнгөн гүйлгээний тайлангаар төвлөрүүлэн зарцуулсан байна. Санхүүгийн

нэгтгэсэн тайланд орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлогыг хоорондын тооцоогоор устгал хийсэн байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн сумын 2021 оны төсөв батлах тухай 02 дугаар тогтоолд зааснаар Алтанбулаг сумын Засаг дарга тайлант онд 292,508.2 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан байна. Төв аймгийн Алтанбулаг сумын ИТХ-ын 2021 оны 11 дугаар сарын 03-ны өдрийн сумын 2021 оны төсөв тодотгон батлах тухай 02 дугаар тогтоолд зааснаар орон нутгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөнд өөрчлөлт ороогүй байна.

Алтанбулаг сумын Засаг дарга тайлант онд 292,508.2 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 488,134.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 197.6 хувиар биелүүлсэн байна. Алтанбулаг сумын орон нутаг төвлөрүүлэх газрын төлбөр 23,826.7 мянган төгрөгөөр тасарсан нь сумаас 3900 га талбайг улсын тусгай хэрэгцээнд авснаас газрын төлбөр ороогүй, нэр зааж ангилагдаагүй орлого 14,793.0 мянган төгрөгөөр тасарсан нь ан агнуурын орлогыг оруулж төлөвлөснөөс, 13,574.6 мянган төгрөгөөр суутган-2 тасарсан нь үйл ажиллагааны орлогод оруулж мэдээлснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 73,748.1 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 1,050,065.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор, нийт 1,123,813.3 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба 346,844.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 404,644.2 мянган төгрөгийн, хандив, бусад эх үүсвэрээр 225,533.9 мянган төгрөгийн, нийт 603,178.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 588,698.3 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хассан байна

Авлага, өглөгийн талаар:

Авлага дансны эхний үлдэгдэл 347,838.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 315,848.9 мянган төгрөг болж 31,989.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд зээлийн хүүгийн авлага 3,557.2 мянган төгрөг, байгууллагаас авах 77,911.1 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 234,380.6 мянган төгрөг, нийт 315,848.9 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн. Үүнд: ЗДТГ-ын 23,000.0 мянган төгрөгийн авлага, ИТХ-ын 4.3 мянган төгрөгийн авлага, Эмнэлэг 51,691.8 мянган төгрөгийн авлага, цэцэрлэг 48.6 мянган төгрөгийн авлага, СХС-ийн зээл, зээлийн хүүгийн хүмүүсээс авах авлага 238,387.8 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн авлага 3,166.4 мянган төгрөгийн авлага байна.

Өглөгийн үлдэгдлээр Эрүүл мэндийн төвийн, 2,781.9 мянган төгрөгийг өглөг байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 487,807.1 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд эмийн эргэлтийн сангийн 8,823.8 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд 1,966.9 мянган төгрөг нийт 498,597.8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Төрийн сангийн харилцах дансанд орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 248,351.8 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 92,523.9 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 128,901.4 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн үлдэгдэл 1,529.7 мянган төгрөг, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн 16,500.3 мянган төгрөг байршиж байна.

Бараа материал 289,846.2 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 14,996,295.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө	164,678.8	498,597.8	333,919.0
Авлага	347,838.6	315,848.9	-31,989.7
Урьдчилгаа			
Бараа материал	248,366.4	289,846.2	41,479.8
Үндсэн хөрөнгө	15,560,003.2	14,996,295.4	-567,707.8
Нийт хөрөнгө	16,320,887.1	16,100,588.3	-220,298.8
Өр төлбөр	0	2,781.9	2,781.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	16,320,887.1	16,097,806.4	-223,080.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	16,320,887.1	16,100,588.3	-220,298.8

Бараа материалын дансны үлдэгдэл 289,846.2 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 41,479.8 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материалын үлдэгдэл 8,928.1 мянган төгрөг, бусад материалын үлдэгдэл 57,384.4 мянган төгрөг, бусад хангамжийн материал 19,378.9 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 14,996,295.4 мянган төгрөг болж 567,707.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 348,844.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө акталснаас шалтгаалсан байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 16,100,588.3 мянган төгрөг болж 220,298.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,679,241.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 2,679,241.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын хүргүүлсэн төсвийн төслөөс 56,256.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж Алтанбулаг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн сумын 2021 оны төсөв батлах тухай 02 дугаар тогтоолд 2,735,497.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь эд хогшил, тоног төхөөрөмж, тэтгэмж, урсгал зардлуудыг бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Алтанбулаг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн орон нутгийн төсөв батлах тухай 03 дугаар тогтоолд зааснаар 3,300.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2,738,797.8 мянган төгрөгөөр төсвийг тодотгон баталсан байна. Алтанбулаг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн орон нутгийн төсөв батлах тухай 4 дүгээр тогтоолд зааснаар Сум хөгжүүлэх сангийн төлөвлөгөөг 201,500.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд Алтанбулаг сумын Засаг даргын хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 2,738,797.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,350,888.9 мянган төгрөгийг бараа үйлчилгээний урсгал зардалд, 136,319.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, урсгал шилжүүлгийн зардалд 50,089.4 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,508,076.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 956,494.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 32,758.6 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 241,468.1 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,461,990.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 956,928.4 мянган төгрөг, 20,695.8 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 172,999.6 мянган төгрөгийг нийт 2,612,613.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч ОНХС-д 15,558.1 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвд 12,062.8 мянган төгрөг, Цэцэрлэгт 375.6 мянган төгрөг, СХС-д 28,500.4 мянган төгрөгийн

санхүүжилт дутуу олгож, 69,686.9 мянган төгрөгийг татан төвлөрүүлж төсвийн тохируулга хийгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,461,996.7 мянган төгрөг буюу 89.89 хувьтай байгаа нь цалин хөлс, НДШ-ийн зардал 41,067.5 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 16,056.7 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 546.0 мянган төгрөг, нормативт зардал 18,684.6 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 5,244.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 190.0 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 1,866.1 мянган төгрөгийн зардлууд хэмнэсэн нь шалтгаалсан байна. Үүнд: сургууль, цэцэрлэг ажиллаагүйгээс үдийн цай хөтөлбөр хэрэгжээгүй, илүү цагийн хөлс олгоогүй, бага сургууль ашиглалтад ороогүйгээс халаалтын зардал хэмнэсэн зэргээс шалтгаалсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 52,723.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 4 төсөл, арга хэмжээнд 136,319.5 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 40,495.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг дарга дээд шатны төсвийн захирагчаас 160,266.0 мянган төгрөг, хандиваар 94,582.3 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 66,131.3 мянган төгрөг нийт 320,979.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, үүнээс цалин, ндш-ийн зардалд 34,860.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 7,758.6 мянган төгрөг, нормативт зардал 53,088.1 мянган төгрөг, эд хогшлын зардалд 7,701.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 56,290.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 104,842.9 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох мөнгөн тэтгэмж 13,832.3 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 9,156.8 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 1,508.0 мянган төгрөг олгож, нийт 319,012.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,966.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг дарга тайлант онд тэр бум мод тарих үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж, нийтийн эзэмшлийн талбай, хатуу хучилттай зам дагуу төсөл хөтөлбөр болон хувийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 3.3 га газрыг хашиж, нийт 45,252.0 мянган төгрөгийн 6354 ш суулгац тарьсан байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг дарга тайлант онд сурагчдын суралцах ая тухтай орчныг бүрдүүлж ЕБС-ийн дотуур байрны дээврийн засварын ажлыг аймгийн хөрөнгө оруулалтаар 69,074.4 мянган төгрөгөөр Хуримт констракшн ХХК хийж гүйцэтгэжээ.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон аж ахуй нэгжтэй байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээгээр Зүүн дэнжийн гэр хороололд шинээр 2 гэрэлт цамхаг байршуулсан бөгөөд уг ажлыг ЭС ЭМ ЖИ ХХК 15,000.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Алтанбулаг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн харьяа байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС-ийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайланд 34,199.0 мянган төгрөгийн залруулга хийгдэж, 128,260.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 585,609.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж, ИТХ-ын санхүүгийн тайланд 2,758.6 мянган төгрөгийн залруулга хийгдэж, 357.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж, ОНХС 16,085.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж, СХС 64,623.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 27,887.2 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөн.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Уваа-Уул Аудит ХХК тус сумын ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, эмийн эргэлтийн сан гэсэн 4 санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан. Аудитаар ЕБС-ийн санхүүгийн тайланд 55,896.1 мянган төгрөгийн залруулга хийгдэж, 600.0 мянган төгрөгийн 7 зөвлөмж, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд 68,823.9 мянган төгрөгийн залруулга хийгдэж, 600.0 мянган төгрөгийн 6 зөвлөмж, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 308,649.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 5 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 136 мэдээллээс хугацаандаа оруулсан 123 мэдээлэл, хугацаа хоцроосон 7 мэдээлэл, мэдээлээгүй 7 мэдээлэл байна. Тус байгууллага 5,0 саяас дээших орлогын 12 мэдээлэл байршуулахаас 10 мэдээлэл байршуулж хугацаа хоцроосон 2 мэдээлэл, зарлагын 12 мэдээлэл байршуулахаас 10 мэдээлэл байршуулж 164,703.0 мянган төгрөгийн 2 мэдээлэл хугацаа хоцроосон, 5,0 саяас дээших худалдан авалтын 2 гүйлгээ байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар хууль тогтоомжтой холбоотой, орон нутгийн орлого бүрдүүлэлтэй холбоотой 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Алтанбулаг сумын Засаг даргын 2021 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 05/330 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 300,028.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 297,682.8 мянган төгрөгийн 5 алдааг залруулж 219,376.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

1.Тус байгууллага жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг ирүүлэхдээ санхүүгийн байдлын тайлангийн цэвэр өмчийн дүн 57,408.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2.Тус байгууллага жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг ирүүлэхдээ мөнгөн гүйлгээний тайлангийн нийт цэвэр мөнгөн гүйлгээ орон нутагт төвлөрүүлэх шилжүүлгийн үлдэгдэл 23,600.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3.ИТХ Тайлант оны мөнгөн гүйлгээний тайланд 2,758.6 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлэг тайлагнаагүй, мөнгөн гүйлгээний тайлан зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4. Соёлын төв Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 106,957.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.Тайлант онд Соёлын төвийн спорт заалыг орлогод тусгахдаа 106,957.4 мянган төгрөгөөр санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн тодруулга тайланд зөрүүтэй тусгаж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Алтанбулаг сумын Засаг дарга орон нутагт төвлөрүүлэх 5 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 54,315.6 мянган төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улс, аймаг, орон нутагт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх.

2. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд оруулбал зохих 136 мэдээллээс хугацаандаа оруулсан 123 мэдээлэл, хугацаа хоцроосон 7 мэдээлэл, мэдээлээгүй 7 мэдээлэл байна. Тус байгууллага 5,0 саяас дээших орлогын 12 мэдээлэл байршуулахаас 10 мэдээлэл байршуулж хугацаа хоцроосон 2 мэдээлэл, зарлагын 12 мэдээлэл байршуулахаас 10 мэдээлэл байршуулж 164,703.0 мянган төгрөгийн 2 мэдээлэл хугацаа хоцроосон, 5,0 саяас дээших худалдан авалтын 2 гүйлгээ байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлж ажиллах.

4.Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

3.ИТХ тайланд онд түүхэн замналын хөрөг зурганд 357.5 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Засаг дарга	3	135,325.0	2	81,009.40					1	54,315.60
2	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	3,116.1	1	2,758.6					1	357.5
3	Засаг даргын тамгын газар	4	162,459.6	1	34,199.0			3	128,260.7		
4	Ерөнхий боловсролын сургууль	10	56,496.1	4	55,896.1					6	600.0
5	Алтанбулаг сумын ОНХС	1	16,085.6							1	16,085.6
6	Эрүүл мэндийн төв	8	308,649.4	4	308,649.4					4	
7	Эмийн эргэлтийн сан	0	0.0								
8	Хүүхдийн цэцэрлэг	9	69,423.9	4	68,823.9					5	600.0
9	Сум хөгжүүлэх сан	2	92,511.0					1	64,623.8	1	27,887.2
10	Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан										
Дүн		39	844,066.8	16	551,336.4			4	192,884.4	19	99,846.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Засаг дарга	1	164,703.0							1	164,703.0
2	Засаг даргын тамгын газар	1	585,609.7							1	585,609.7
3	Ерөнхий боловсролын сургууль	1								1	
4	Эрүүл мэндийн төв	1								1	
5	Хүүхдийн цэцэрлэг	1								1	
Дүн		5	750,312.7							5	750,312.7
Нийт дүн		44	1,594,379.5	6	556,798.5	9	34,197.9	8	119,982.0	25	850,158.7

6. Байгууллагын санал дүгнэлт

№	Байгууллагын нэр	Санал дүгнэлтийн хэлбэр				
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс	Дүн
1	Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газар	1				1
2	Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль	1				1
3	Төв аймгийн Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэг	1				1
4	Төв аймгийн Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төв	1				1
Дүн		4				4

